МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 03 өдөр Дугаар А/02 Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйл 8.1.1, авто замын тухай хуулийн 12 дугаар зүйл 12.1.2 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Могойн гол" ХХК-ний үйл ажиллагаа, нүүрс олборлолт, тээвэрлэлт болон Могойн голоос Эрдэнэтийн чиглэлд нүүрс тээвэрлэж буй зам, гүүрийн ашиглалтын байдалд хяналт шалгалт явуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Ажлын хэсэгт орсон агентлаг, байгууллагуудын төлөөлөл удирдамжийн хүрээнд хариуцсан чиглэлээр хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулж, хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг аймгийн Засаг даргад илтгэх хуудсаар ирүүлж ажиллахыг Ажлын хэсгийн гишүүдэд, хяналт шалгалтын ажлын үр дүнг нэгтгэн 2022 оны 01 дүгээр сарын 15-ны дотор аймгийн Засаг даргад танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Х.Ган-Очир)-д даалгасугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 03.-ний өдрийн А/02 дугаартай захирамжийн 1 дүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: М.Хуягбаатар-(Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүдэд: Д.Түмэнбаяр-(Мэргэжлийн хяналтын газрын дарга)

Д.Бямбацогт- (Мэргэжлийн хяналтын газрын Геологи уул уурхайн хяналтын Улсын байцаагч)

Б.Даваасүрэн (Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын Улсын байцаагч)

Б.Батбилгүүн (Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын Улсын байцаагч)

Н.Буян-өлзий (Мэргэжлийн хяналтын газрын Авто замын хяналтын Улсын байцаагч)

Б.Ганзориг (Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн ахлах зохицуулагч, дэд хурандаа)

М.Амарбаясгалан (Авто тээврийн төвийн авто тээврийн хяналтын мэргэжилтэн)

Н.Шинэбаяр (Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)

Д.Оюунбилэг (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

Т.Мөнхбаатар (Хөвсгөл АЗЗА ХК-ийн ерөнхий инженер)

Нарийн бичгийн дарга: (Ё.Батсайхан аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн)

___oOo____

Аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр
сарын 03 өдрийн А/02 дугаартай
захирамжийн 2 дугаар хавсралт

ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ УДИРДАМЖ

Нэг. Шалгалтын зорилго, үндэслэл

Цэцэрлэг сумын Могойн гол ХХК-ний нүүрс олборлолт, тээвэрлэлт болон Могойн голоос Эрдэнэтийн чиглэлд нүүрс тээвэрлэж буй зам, гүүрийн ашиглалтын байдалд Монгол улсын Төрийн хяналт шалгалтын тухай, Ашигт малтмалын тухай хууль, Авто замын тухай, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуулиуд болон авто замын норм, дүрэм, стандарт зэргийг хяналт шалгалт явуулахад оршино.

Хоёр: Хугацаа

Хяналт шалгалтыг 2021 оны 01 дүгээр сарын 05-ний өдрөөс 2021 оны 01 дүгээр сарын 07- ны өдөр хийж гүйцэтгэнэ.

Гурав:Хяналт шалгалт хийх чиглэл, хамрах хүрээ

1. Ил уурхайн үйл ажиллагааг шалгах
2. Хөдөлмөрийн харилцааг болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах
3. Автозамын норм, дүрэм, стандартын хэрэгжилт, авто зам, Хилэнтийн гүүрний нөхцөл байдлыг шалгах,
4. 2020, 2021 онд байгуулсан нүүрс худалдах, тээвэрлэх гэрээ, түүний хэрэгжилт
5. Могойн ХК-ний Хөвсгөл, Завхан аймгаас бусад газарлуу нүүрс борлуулсан, тээврийн гэрээний хэрэгжилт тээвэрлэсэн нүүрсний тоо хэмжээг аж ахуй нэгж бүрээр тодорхойлох.
6. Могойн гол ХК-ний хөрс хуулалт, уулын ажлын төлөвлөгөө, бизнес төлөвлөгөөтэй танилцаж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах.
7. Могойн голын нүүрсний уурхайгаас Мөрөн хүртэлх авто замаар зорчиж байгаа нүүрс тээврийн хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөлөл, нөхцөл байдалтай танилцах,
8. Уурхайгаас тээвэрлэгдэж байгаа нүүрсний тонн жинтэй холбоотой уурхайн жингийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх.

Дөрөв: Үр дүн

Хяналт шалгалтын үр дүнд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулж танилцуулах.

Өөрсдийн хариуцсан чиглэлээр хуулийн хэрэгжилтийг хангуулж, шаардлагатай арга хэмжээг авч зөвлөмж, шаардлагыг өгч түүний хэрэгжилтийг хангуулж ажиллах.

_____oOo_____